



“ТЭЖЭЭЛИЙН УРГАМАЛ”

ХОВД АЙМГИЙН ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН
“ЦАМБАГАРАВЫН ЭНГЭР” БАХ

2020 ОН

Төсөл хэрэгжсэн газар.

Ховд аймаг Эрдэнэбүрэн сум:

Төслийн зорилго.

Өндөр уулын бүс нутагт малын тэжээлийн нөөцийн хомсдолд өртөмтгий, үе үеийн зуданд мал сүрэг олноор хорогдох, малчдын амжиргааны нөхцөл тогтворгүй тул малын тэжээлийн ургамал сонгон тариалж, нөөц бүрдүүлж орон нутагтаа өртөг багатай хямд тэжээл бий болгох зорилготой .

Төслийн зорилтууд.

Уг төслийг хэрэгжүүлснээр усалгаатай газар тариалан эрхэлж талбайдаа малын ногоон тэжээлийн ургамал тариалж, туршилт хийх өөрсдийн өрхийн хэрэгцээ, БАХэсгийн малчин өрхийг хангах

Үйл ажиллагаа.

Сумын “Цамбагаравын энгэр” Бэлчээр ашиглагчдын холбооны талбайд 2020 онд ногоон тэжээл тариалахаар ТББ-н удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцээд, бэлтгэл ажлаа хангаж, 3 га газарт овъёос тариаллаа.

Хиймэл нуурны ус оройтож ирсэн тул тариалалтын ажил оройтон 6 дугаар сарын 1 –ээс эхлэн талбайн суваг шуудуйгаа сэргээн засварлаж, трактороор татуулан усалгаагаа хийж, тариалалт хийх үед Бэлчээр ашиглагчдын хэсгийн малчдаас чөлөө завтай 5 хүн авч ажилууллаа.

40 килограммтай 18 уут овъёос тус бүрийг нь 24000 төгрөгөөр худалдан авч 3 га газар тариаллаа.

Суваг шуудуй татах, газар хагалах, үр суулгах, ногоон тэжээлээ хадуулах, самнуулах, бутлах үед трактортой хувь хүмүүстэй харилцан тохиролцон ажлын хөлс өгч ажиллалаа.

Зуны 4 сарын хугацаанд манаач, усалгаа хийх хүнтэй нэг сард 200000 төгрөгөөр тохиролцон 800000 төгрөг өгч цалинжуулсан болно.

Ногоон тэжээлээ болц гүйцээд шарласны дараа /90 хоног/ хадуулан, самнаж, каадуугаар бутлуулан нунтаг хивгэн тэжээл болгон 320 уут тэжээл болгон нөөцлөн авлаа.

Цаг агаар хүндэрвэл БАХэсгийн малчин өрхөдөө нэг уутыг нь 12000 төгрөгөөр олгохоор төлөвлөн ажиллаж байна.

Төслийн хөрөнгө оруулалт.

Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Санхүүжилт, төгрөг
Төслөөс	3000000
СБАХ	1000000

Хөрөнгө оруулалтын зарцуулалт.

д/д	Хийгдсэн ажил /шаардагдах материал/	Хугацаа	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Усны суваг шуудуй татах, сэргээх, усалгаа хийх / шатхуун/	6 дугаар сарын 1-5 - ны хооронд	литр	139	2080	289400
2	Тариалалт хийх ажилчдын хоол хүсэнд /хонь, хоол хүнсний материал/	6 дугаар сарын 1-15- ны хооронд	=	=	=	255000
3	Тариалалт хийх газар хагалахад	6 дугаар сарын 5-7-ны хооронд	га	3	150000	450000
4	Үр худалдан авхад /овъёос/	6 дугаар сард	ш	18	24000	432000
5	Үрэлгээ хийхэд	6 дугаар сарын 8-9- ний хооронд	га	3	60000	180000
6	Манаач хийх, усалгаа хийх хүний цалин хөлс	6,7,8,9 дүгээр сард	сараар	4	200000	800000
7	Ногоон тэжээлээ хадахад /шатхуун, ажлын хөлс/	09 дүгээр сарын 15-18	литр	100	2080	208000
		Жолоочод	төгрөг	1	100000	100000
8	Хадсан ногоон тэжээлээ самнахад /шатхуун/	09 дүгээр сарын 18-19	литр	30	2080	62400
9	Уут авахад	09 дүгээр сарын 18	ширхэг	350	500	175000

10	Ногоон тэжээлээ каадуудаж тэжээл болгоход /шатхуун/	09 дүгээр сарын 20-25	литр	40	2080	83200
		Жолоочод	төгрөг	1	100000	100000
11	Ажилчдын хоол хүнсэнд /хонь, хоол хүнсний материал/	09 дүгээр сарын 15-26	=	=	=	165000
12	Ажилчдын цалин хөлс	09 дүгээр сарын 20-25/5 өдөр	төгрөг	4	15000	300000
Дүн						4000000

Борлуулалт, үйлчилгээний орлого.

№	Бүтээгдэхүүн, үйлчилгээ	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт, төг
1	Хивэг /ногоон тэжээл/	уут	320	12000	3840000
Нийт					3840000

Нэг уут ногоон тэжээл 12000 төгрөг зарж борлуулхад 3840000 төгрөг ба 15000 төгрөгөөр зарвал 4800000 төгрөг болох боломжтой

Төслийн үр дүн.

Төсөл хэрэгжиснээр сум орон нутагт урьд өмнө тэжээл үйлдвэрлэж байгаагүй, орон нутаг тэжээл хийдэг болж байгаа нь давуу тал болно.

Зах зээлийн ханшаар үйлдвэрийн хивгэн тэжээл 25000-28000 төгрөг байгаа тул борлуулалт сайн болно гэсэн дүгнэлт гарч байна.

Энэ жилийн орлогоор цаашид үйл ажиллагаагаа явуулах бүрэн боломжтой болсон. Нэг уут хивгэн ногоон тэжээлийг 15000 төгрөгөөр зарвал 800000 төгрөгний цэвэр ашигтай ажиллана.

Хивэг хийснээр сум орон нутаг тэжээлийн үйлдвэртэй болж байгаагаан зэрэгцээ цаашид өөрийн брэнд бүтээгдэхүүнтэй болох.

БАХ-ын малчид орон нутагт хийсэн хямд чанартай тэжээл хэрэглэснээр орлого нэмэгдэж, санхүүд хэмнэлттэй болно.

Тэжээл үйлдвэрлэснээр сумын БАХ-н малчид үр шимийг хүртэх бүрэн боломжтой.

Төслийн үр шим хүртэгч.

Бэлчээр ашиглагчдын малчид үр шимийг нь бүрэн хүртэх боломжтой




Төслийн зориулалт.


Төслийн зориулалт нь сумын БАХ-ийн нийт малчин өрхийг өртөг багатай орон нутагт үйлдвэрлэсэн чанартай тэжээлээр хангах, цаашид ТББайгууллага өөрөө өөрийгөө санхүүжүүлэн авч явах боломжоор хангах.

























ТАЙЛАН БИЧСЭН
ТББ-ЫН ТЭРГҮҮН



Н. ЛХАМСҮРЭН